



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Бүгд найрамдах Солонгос Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй (Ойн газрын ашиглаж буй) Монгол-Солонгосын хамтарсан "Ногоон хэрэм" төслийн санхүүжилтээр бий болсон 133,126,000.00 (нэг зуун гучин гурван сая нэг зуун хорин зургаан мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Сэлэнгэ аймгийн Ерөөгийн бүсийн Сум дундын ойн ангийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001873
19-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн
386 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН "НОГООН ХЭРЭМ" ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЕРӨӨГИЙН БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

№	Байгууллагын нэр	Марк, дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ (төгрөг)
1	Сэлэнгэ аймгийн Ерөөгийн бүсийн сум дундын ойн анги	Улсын дугаар 16-83 УЕУ, Hyundai Porter (HS- 1300PFE)	KMFZBZ7KCPU08 3652	2024	1	ш	133,126,000.00
Дүн							(нэг зуун гучин гурван сая нэг зуун хорин зургаан мянган